

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**[20 оноо]****Санамж:**

1. Эхийг анхааралтай уншин асуулт даалгавар бүрийг гүйцэтгээрэй.
2. Сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
3. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг дугуйлаарай.
4. Даалгавар бүр 2 оноотой.

Нохой гэрт хүн урдаггүй /өгүүллэг/

Газар тэнгэрийн савслагаас нар таширлан хорвоо дэлхийг алтруулав. Түгжав тууврын мал тууж одсон Донойнх өөд яралзуулахад, ухаа зээрд морь нь оройн наранд гал адил цоролзож байна. Айлуудын эзлэнд бух урамдаж, өдөржин адуу хурсан нуурын зүгээс шивтэр ханхална. Нуурын хөвөөгөөр Түгжавыг хайр чулуунд мориныхоо дөрвөн хөлийг балбалзуулан хажигнаж явахад нар шингэж билээ. Хөлөрсөн ухаа зээрд морь нар жаргасан хойно бараан, болон сүүтэлзэж, өдөржин адууны хөлд цалгилж ядарсан нуур үдшийн бүрэнхийд тогтож ядан цэлэлзэх нь нойрсохоор яарах мэт авай.

...Түгжавын бараанаар ээлүүд талын ганц гэрээс даага шиг хар нохой дүүлэн гарч ирлээ. Донойн энэ нохой чоно барьдгийн гадна Түгжавыг үзэн ядна. Хар нохой морины хоёр талаар сэлгэн Түгжавын нүүр өөд үсчихэд нялуун үнэртэй халуун амьсгал нь хан ханхийж, аймшигт араа соёо нь ярзалзаж байв. Тэнзэн ташуураараа Түгжав нохойны сарьсан хамар дээр дэлсмээр хорхойтсон боловч зорьсон хэргээ бодож биеэ барив. Тэгээд нохойд өвдөг хөлөө хазуулчихгүйн тулд том ташуураа хий зангаж явлаа. Уур нь дэлбэрэх шахсан нохой урилгагүй зочныг гэртээ ойртох тусам л хилэгнэж, ухаа морийг зогсоохоор сүүлнээс нь чаргууцалдсанаа хүч хүрэлгүй Түгжавын ган дөрөөг тан янхийтэл хазлав.

Донойн гэргий Хандмаа гэрээсээ гарч нохойгоо хорихоор гүйх замдаа үс гээг, дээл хувцсаа янзалж явна. Тэр бээр нохой руугаа гүйж очоод "Хол яв! Байтлаа гэрт хүн буулгахгүй нь уу!" гэж зандрахад хар нохой арга буюу нохойн ёсоор эзнийхээ өмнө газар хэвтээд хүлцэнгүйгээр гийнан мөлхөх авч үзэн ядсан уур нь багтаж ядан хахаж цацна. Түгжавыг уяанаас морио уяад гэр өөд явахад хар нохой хүзүүвчнээсээ зуурсан Хандмааг чирч хоолой хяхтнуулан зүтгэхэд эзний нь хормой ярагдаж хоёр урт цагаан гуя гялалзан урагш хөвчлөн жийгээд нойтон газар онгилон улдав. Хар нохойг турьхан эзнийхээ гараас мултарч ирээд толгой дээрээ мордчих вий гэж айсан Түгжав гэрт орохоор яарч, ичсэндээ хажуугийн хүн харахад нударга хаялан хаахалзаж, ачир дээрээ явган явж үзээгүй хоёр богинохон хөлийнхөө чадлаар гүйж байв. Тэр бээр үүдээр шургуут нуруу хотосхийлгэн хаалга хавхийтэл хаагаад тулганы хойно гарч зогслоо. Хар нохой гэрт орж, Түгжавтай үзэлцэхээр Хандмаатай уралдан дайрч хаалганд хоншоороо хавчуулаад өвдсөндөө биш, ууртаа гаслан хоцров. Түгжавын санаа бага зэрэг тайвширч:

-Мөн ч ширүүн байх чинь вэ? гэхэд Хандмаа:

-Чамд ширүүлэхгүй бол өөр хэнд ширүүлэх вэ гээд зургар хар нүдээ маяглуулав.

-Доной догь хүн, авгайдаа хатуухан манаач тавьжээ. Хар нохой байхад Донойн сэтгэл өдийд амар яваа биз. Гэвч хөөрхий, даанч адгуус юм даа гээд Түгжав хоймрыг шилбүүрдвэл жаазнаас гэрийн эзний том хөрөг яг өөрийг нь ширтэж байхуйд, тэр ялимгүй займарч суув. Хандмаа алтан ээмгээ санжганатал гунхалзаад:

-Адгуус ч гэж басаж болохгүй шүү. Манай хар нохой Донойтой бол ярьдаг юм гэлээ.

Түгжав "ха, ха" хэмээн худлаа хөхрөөд тухлахаар сүүжилдэн хэвттэл хар нохой гэнэт дахин хуцав. Түгжавын дотор эвгүй бодол ургаж өндийнгүүт малгайгаа авч хааш яаш өмсөөд их л хүнийрхүү цомцойн суулаа. Тэгээд "Донойн ирэх юу болж байгаа билээ" гэж асуух гэтэл, Хандмаа ухасхийн хаалгаар шагайж хараад:

-Хүүш ээ яана аа, Түгжав аа! гээд чимээ тасрав. Тэгснээ:

-Манай энэ нээрэн муухай гударга шүү. Уяан дээр очоод, чиний морийг боргоод уналаа гээд урьхнаар аальгүйтэн инээв.

Хандмаа Түгжавт идээ цай болсны дараа эртхэн үнээгээ саахаар гарлаа. Түгжав хоёр гутлаа тайлж орхиод гэрийн баруугаар хажуулав. Гадаа хар нохой түүний морийг ээрсээр авч уур хилэн нь нэлээд буурчээ. Эцэстээ тэр хаа нэгэнтээ пөн пөн үглэснээ Түгжавын моринд дасав уу, аль эсвэл залхав уу, эрүү хамхив.

Түгжав үс болсон хоёр панцгар хөл жийж, авдар шиг зузаан цээж түхэлзүүлэн зүүрмэглэв...

Хаалга гэнэт торхийв. Цочин харвал хаалганы завсраар хар нохойны сарьсан хамар орж ирээд ийш тийш шиншилж гарлаа. Түгжавын дотор палхийж, өндийх гэснээ болиод огт хөдлөхгүй нам хэвтэхээр шийдэв. Хар нохой сэтэрхий хамраа сартгануулан баахан шиншилснээ хошуугаараа хаалга



сөхөн түлхтэл, түрхийх чимээ гарч цээжин бие нь гэрт ороод ирлээ. Түгжав баруун орон дээр үсрэн гарах гээд амжсангүй. Хар нохой баримжаа муутай түлхэж гэрт лав орж ирсэндээ гэмшсэн байдалтай хулчгар царайлан хойш ухарсаар, дөнгөж толгойгоо хаалгаар цухуйлгасны эцэст сая санаа амарч, бүрий орж буй гэрийн доторхыг ажиглан гэмшингүй шар нүдээ гөлөгнүүлэв. Түгжав "Хандмаа" гэж хашхирах гэснээ хэрэг бүр бишдэх байх гээд үхсэн мэт амьсгал хураав.

Нохой гэр доторхыг сайтар ажиглаад хар нь бага зэрэг арилсан янзтай зүүн хатавчнаас эхлэн өөх тосны цөвдөл, шороо пургиулан шиншилсээр босго алхлаа. Түгжавын цогцсоос зөвхөн хар нүд нь аяган дотроо хөдөлж, гартаа барьчих багаж зэвсэг ойр хавиас хайна. Хар нохой эргэнзгийн урдуур нүүгэлтэн орж ирэхэд сүүл нь хөвөрсөөр хаалганаас мултарч хаалга хаагдлаа. Түгжавын дотор өрхийг нь бүтээсэн гэр шиг пад харлав. Донойн чоно барьдаг хар нохой бүрэнхий гэрт орж ирээд зогсож байгаа нь баавгай шиг сүртэй ажээ. Тэр баавгай гэрийн зүүн талаар шиншлэн өөдөө ахисаар хоймор дөхөж ирлээ. Нохойны хамар нүүрний нь дэргэд ирж, сахал салмайг нь сэрвэлзтэл шуухитнахад Түгжавын хар нүд ч хөдлөхөө болиод айсандаа хөлдөж орхив. Хар нохой дун цагаан араа соёогоо ярсхийтэл эвшээж, урт улаан хэлээр амаа гаслантайяа долоосноо тулганы хойгуур баруун тийш тойрохоор дээш ахилаа. Түгжав амьсгалахаа болив. Тэгтэл хар нохой гэнэт хаалга руу зүүн талаар буцлаа.

Түгжав дотроо залбирч цээжиндээ хураасан амьсгалаа сэмхнээр цувруулан гаргав. Хар нохой (ёсыг бодоод тулганы хойгуур тойрсонгүй бололтой) эрлээ баруун хатавчнаас өөд нь үргэлжлүүлэв. Энэ удаа хар нохой Түгжав хоёр золгох нь зайлбаргүй болжээ. Зугтаасан хүнд нохой өстэй байдгийг мань хүн мэдэх тул гуалин шиг хэвтэж байгаад азаа шодохоор шийдэв. Хар нохой Түгжавын нүцгэн хөлд сайран хамраа хүргэхээд давхийн цочлоо. Түгжав цочсон ч үгүй, бүх ухаанаа дайчлан мод болон хөшив. Тэр ерөөсөө л үхсэн хүн больё гэсэндээ бараг үхжээ. Хамаг бие нь цэл хөрж, зүрх нь зогсоод цус нь зөвхөн айснаасаа болоод гүйж байлаа. Түүний амьд гэдгийг хар нохой байтугай Түгжав өөрөө ч мэдэхээ больжээ. Хар нохой хэсэг зогсоод Түгжавын хөлийг "Энэ ер нь юу вэ?" гэсэн шиг дахин шохоорхож, өөд нь ахиулан шилбэ, гуяыг үнэртэж үзэв. Түгжавыг тэр амьгүй бодис гэж санасан байдалтай дээгүүр нь алхаад нүцгэн гэдэс хэнхдэгийг нь шиншлэв. Түгжав хар нохойг багалзуурдаад авах уу гэснээ ямар ч байсан эхэлж өдөхөө больё гэж шийдээд ирээдүйн дайнд битүүхэн бэлтгэв.

Чингэтэл хар нохойны харц Түгжавын харцтай яг тулгарав. Өөрийг нь амьд гэдгийг нохой түүний хөлдүү харцнаас мэдлээ. Нохойны гэрт орж ирсэндээ гэмшсэн хулчгар нүдний цаад өнгөнд түрүүчийн хонзон гялалзаж байгааг Түгжав харав. Түгжавын нүдний амьд галыг хар нохой хэсэг гайхан ажигласнаа гэнэт далдирч ухасхийн гарч одов. Гарч явахдаа түүнийг сүүлээ тас хавчсан байсныг Түгжав анзаарчээ. Хар нохой гадаа гаруут Түгжавын морийг хилэнтэйеэ ээрч гарав. Түгжав нохойд багалзуураа тас хазуулаагүйдээ баярласан боловч дотор нь хачин болж орхилоо. Тэр босож суув. Айлын эзгүй гэр нэг л таагүй, хоймрын жаазнаас ширтэх Донойн харц өөд Түгжав харах гээд чадсангүй.

Монгол улсын төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Цэндийн Доржготов

1. Эхэд орсон дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. цоролзох	a. цохих
2. сэлгэх	b. буруулах
3. дэлсэх	c. явах
4. займрах	d. хоргоох
5. боргох	e. солих

A. 1c. 2e. 3a. 4d. 5b. B. 1a. 2e. 3c. 4d. 5b. C. 1e. 2c. 3a. 4b. 5d.

D. 1e. 2a. 3c. 4d. 5b. E. 1c. 2e. 3a. 4b. 5d.

2. Өгүүлэлийн сэдвийг тодорхойлж чадахуйц хэсгийг сонгоорой.

- A. Уур нь дэлбэрэх шахсан нохой урилгагүй зочныг гэртээ ойртох тусам л хилэгнэж, ухаа морийг зогсоохоор сүүлнээс нь чаргууцалдав.
- B. Донойн гэргий Хандмаа гэрээсээ гарч нохойгоо хорихоор гүйх замдаа үс гээг, дээл хувцсаа янзалж явна.
- C. "Хол яв! Байтлаа гэрт хүн буулгахгүй нь уу!" гэж зандрахад хар нохой арга буюу нохойн ёсоор эзнийхээ өмнө газар хэвтээд хүлцэнгүйгээр гийнан мөлхөнө.
- D. Тэр бээр үүдээр шургуут нуруу хотосхийлгэн хаалга хавхийтэл хаагаад тулганы хойно гарч зогслоо.
- E. Адгуус ч гэж басаж болохгүй шүү. Манай хар нохой Донойтой бол ярьдаг юм гэлээ. Түгжав "ха, ха" хэмээн худлаа хөхрөөд тухлахаар сүүжилдэн хэвтэл хар нохой гэнэт дахин хуцав.



3. Тодруулсан хэсгийн хэв маягийг тодорхойлоорой.

- A. Үйл явдлыг цагийн болоод үйлийн дараалалтай хүүрнэсэн тул хүүрнэмж
- B. Үйл явдал болж байгааг харан яахаа бодон айж байгаа тул эргэцүүлэмж
- C. Үйл явдлыг нэгэн цагт тоочин дүрсэлсэн учир тоочимж
- D. Үйл явдал хэрхэн өрнөж байгааг нэг бүрчлэн тайлбарласан тул тайлбарламж
- E. Үйл явдлыг нарийн тоочин тайлбарласан тул тоочимж, тайлбарламж хосолсон

4. Өгүүллэгийн "...ичсэндээ хажуугийн хүн харахад нударга хаялан хаахалзаж, ачир дээрээ явган явж үзээгүй хоёр богинохон хөлийнхөө чадлаар гүйж байв" хэсэгт аль дүрслэх ур маягийг ашигласан байна вэ?

- A. хэтрүүлэл
- B. тойруулал
- C. адилтгал
- D. харшуулал
- E. ихэсгэл

5. Өгүүллэгт "Хар нохой (ёсыг бодоод тулганы хойгуур тойрсонгүй бололтой) эрлээ баруун хатавчнаас өөд нь үргэлжлүүлэв" гэжээ. Энэ нь монголчуудын уламжлалт ямар ёс вэ?

- A. Гаднын зочин хойморт сууж болдоггүй, айлын мал идээнд муу.
- B. Гаднын хүн хоймрын бурхан, гал голомт хоёрын завсраар туулдаггүй.
- C. Айлын эхнэр хүүхдийг гэрийн баганаас хойш гаргадаггүй.
- D. Айл нохой, мал зэргээ гэр орондоо оруулдаггүй.
- E. Нохойг гэрийн хойморт гаргах нь адуу малд харш гэж үздэг.

6. Өгүүллэгийн "Адгуус ч гэж басаж болохгүй шүү. Манай хар нохой Донойтой бол ярьдаг юм" хэсгээр дүрийн сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ?

- A. баярлаж хөөрсөн
- B. өдөж хоргоосон
- C. тохуурхаж тоглосон
- D. шоолж басамжилсан
- E. бахдаж биширсэн

7. Өгүүллэгийн үйл явдал "Хар нохой гадаа гаруут Түгжавын морийг хилэнтэйеэ ээрч гарав" гэжээ. Ийм байдалд хүрэхэд ямар нөхцөл нөлөөлсөн бэ?

- A. Адгуус ч гэж басаж болохгүй шүү. Манай хар нохой Донойтой бол ярьдаг юм гэлээ.
- B. Түгжавын нүдний амьд галыг хар нохой хэсэг гайхан ажигласнаа гэнэт далдирч ухасхийн гарч одов.
- C. Энэ удаа хар нохой Түгжав хоёр золгох нь зайлбаргүй болжээ. Зугтаасан хүнд нохой өстэй байдгийг мань хүн мэдэх тул гуалин шиг хэвтэж байгаад азаа шодохоор шийдэв.
- D. Нохой гэр доторхыг сайтар ажиглаад хар нь бага зэрэг арилсан янзтай зүүн хатавчнаас эхлэн өөх тосны цөвдөл, шороо пургиулан шиншилсээр босго алхлаа.
- E. Түгжавын бараанаар элүүд талын ганц гэрээс даага шиг хар нохой дүүлэн гарч ирлээ. Донойн энэ нохой чоно барьдгийн гадна Түгжавыг үзэн ядна.

8. Өгүүллэгийн "Түгжав"-ын дүрийн мөн чанарыг хамгийн сайн тодотгож өгсөн хэсгийг сонгоорой.

- A. Айлын эзгүй гэр нэг л таагүй, хоймрын жаазнаас ширтэх Донойн харц өөд Түгжав харах гээд чадсангүй.
- B. Тэнзэн ташуураараа Түгжав нохойны сарьсан хамар дээр дэлсмээр хорхойтсон боловч зорьсон хэргээ бодож биеэ барив.
- C. Түгжав үс болсон хоёр панцгар хөл жийж, авдар шиг зузаан цээж түхэлзүүлэн зүүрмэглэв...
- D. Түгжав нохойд багалзуураа тас хазуулаагүйдээ баярласан боловч дотор нь хачин болж орхилоо.
- E. Нуурын хөвөөгөөр Түгжавыг хайр чулуунд мориныхоо дөрвөн хөлийг балбалзуулан хажигнаж явахад нар шингэж билээ.

9. Өгүүллэгт "Тэнзэн ташуураараа Түгжав нохойны сарьсан хамар дээр дэлсмээр хорхойтсон боловч зорьсон хэргээ бодож биеэ барив" гэжээ. Ингэх болсны шалтгаан ямар үйл явдлаас тодорч байна вэ?

- A. -Доной догь хүн, авгайдаа хатуухан манаач тавьжээ. Хар нохой байхад Донойн сэтгэл өдийд амар яваа биз.
- B. Хандмаа гэрээсээ гарч нохойгоо хорихоор гүйх замдаа үс гэзэг, дээл хувцсаа янзалж явна.
- C. Чамд ширүүлэхгүй бол өөр хэнд ширүүлэх вэ гээд зургар хар нүдээ маяглуулав.
- D. Нохойны гэрт орж ирсэндээ гэмшсэн хулчгар нүдний цаад өнгөнд түрүүчийн хонзон гялалзаж байгааг харав.
- E. Хол яв! Байтлаа гэрт хүн буулгахгүй нь уу" гэж зандрахад хар нохой арга буюу нохойн ёсоор эзнийхээ өмнө газар хэвтээд хүлцэнгүйгээр гийнан мөлхөнө.



10. Өгүүллэгийн гол санааг илэрхийлсэн хэсэг аль нь вэ?

- A. Айлын эзгүй гэр нэг л таагүй, хоймрын жаазнаас ширтэх Донойн харц өөд Түгжав харах гээд чадсангүй.
- B. Түгжав нохойд багалзуураа тас хазуулаагүйдээ баярласан боловч дотор нь хачин болж орхилоо. Тэр босож суув.
- C. Нохойны гэрт орж ирсэндээ гэмшсэн хулчгар нүдний цаад өнгөнд түрүүчийн хонзон гялалзаж байгааг Түгжав харав.
- D. Чингэтэл хар нохойны харц Түгжавын харцтай яг тулгарав. Өөрийг нь амьд гэдгийг нохой түүний хөлдүү харцнаас мэдлээ.
- E. Гарч явахдаа түүнийг сүүлээ тас хавчсан байсныг Түгжав анзаарчээ. Хар нохой гадаа гаруут Түгжавын морийг хилэнтэйеэ ээрч гарав.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

[30 0100]

Санамж:

- Даалгавар тус бүрийн зааврыг анхааралтай уншиж гүйцэтгээрэй.
- Даалгаврын хариуг шалгалтын дэвтрийн зохих зайд бичиж тэмдэглээрэй.
- Даалгавар бүрийн оноо харилцан адилгүй болно.

2.1. Дараах эхийг уншин зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай үгийг олж зөв болгон зассан тохиолдол тус бүр 1 оноо [5 оноо]

Толгодын араншин

Загсаасан өрөм шиг талын дундах олон ижил намжаа толгод тулаад үзэхлээр өөр өөрийн өнгө аястай, өөр өөрийн нууц увидастай байдаг. Толгод бол уруугаа ургасан уулс, эрдэнэ нуугаад босгосон шав юм. Хүний чанарыг ханилан байж танихын адил толгодын араншинг явж үзэж гэмээ нь мэднэ. Хонхор бүхэн энд тэнгэрийн толгод болохоор орой бэл гэж ярихад бэрх. Толгод уулс адил уриж дуудан, өөрийгөө алсаас суртчилан зарлах нь үгүй, хадган зэрэглээгээр оройгоо тэгшилж, их талынхаа өнгөнд уусан нуугдах дуртай. Гэвч толгодын сэвшээ найрны дуу шиг соронзтой болохоор түүнийг тойрч гарч болдог, оройны чийг, өвсний шүүдрээр бэлдээ бууж болдог, орой бэл ижилхэн цэцэгтэй байдаг нь хүн төрлөхтөнд заасан байгаль багшийн хичээл мэт.

Жагдалын Лхагва “Толгодын цаана ингэ буйлна эмхэтгэл 2017он” 431-р тал

Алдаатай бичсэн үг	Засаж бичсэн үг

2.2. Дараах цогцолборыг уншаад кирилл бичигт хөрвүүлээрэй.

[5 0100]

0-1 алдвал 5 оноо, 2-3 алдвал 4 оноо, 4-5 алдвал 3 оноо, 6-7 алдвал 2 оноо, 8-9 алдвал 1 оноо, 10-с дээш алдвал 0 оноотой болно.

[illegible]

Түүний тулд хэрхэн буйгаа “**Миний сонгосон мэргэжил**” сэдвийн дор сийрүүлэн бичнэ үү.

Бичгийн соёл оноонд нөлөөлөхийг анхаарна уу.

/Үгийн тоо 200-250/

[20 0100]



Даалгавар	Зөв бичих чадвар	Үндэсний бичгээр унших чадвар	Эх зохион найруулах чадвар							
			Сэдэв ба зорилго	Бүтэц	Эшлэл баримт	Бичлэгийн хэлбэр төрөл	Хэл зүй, найруулга	Үгийн тоо	Зөв бичгийн дүрэм	Бичгийн соёл
Авбал зохих оноо	5	5	5	3	2	2	3	1	3	1
Авсан оноо										

Дүгнэж оноожуулсан багшийн код

